

Жижигхэн заан ба Родзил

Жижигхэн заан Украйны Родзил хотод маш дуртай.

Гэвч Родзил хот амьдрахад нэлээд аюултай учраас жижигхэн заан маань өөр хот сонгохоор шийджээ. Жижигхэн заан маань замдаа их цаг зарцуулах хүсэлгүй байгаа тул хамгийн бага цаг зарцуулах хотыг сонгох гэж байгаа. Хэрвээ сонгож болох хот олон байвал тэр хаашаа ч явахгүй.

Түүнд Родзилоос бусад хотууд руу явах цаг өгөгдсөн бол аль хот руу явахыг хэвлэнэ үү. Хэрвээ Родзилдоо үлдэх бол "Still Rozdil" гэж хэвлэ.

Input

Эхний мөрөнд нийт хотуудын тоо n ($1 \leq n \leq 10^5$) өгөгдөнө. Дараагийн мөрөнд n тоо өгөгдөх бөгөөд хотуудын мэдээлэл байна. i -р тоо нь i -р хот руу явахад зарцуулах хугацаа байх бөгөөд эерэг, 10^9 -с хэтрэхгүй тоо өгөгдөнө.

Та хотуудыг 1-ээс n хүртэл дугаарлагдсан ба Родзил хот тэр дунд байхгүй гэж үзээрэй.

Output

Жижигхэн зааны явах хотын дугаарыг хэвлэнэ. Хэрвээ хамгийн бага хугацаа зарцуулах олон хот байх юм бол "Still Rozdil" гэж хашилтгүйгээр хэвлэ.

Example

Input 1:

2

7 4

Output 1:

2

Input 2:

7

7 4 47 100 4 9 12

Output 2:

Still Rozdil